



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/24

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг зөрчиж ёс зүйн зөрчил гаргасан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Г.Энхбаярыг сонсох ажиллагааг хийх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь нарыг томилсугай.

Хоёр. Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу хийж гарсан саналыг 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА